ЕСҮС ГЭЖ ХЭН БЭ?

Орчлон ертөнцийн үүсэл

Олон мянган жилийн өмнө Ертөнцийн Эзэн энэ ертөнцийг бүтээсэн байна. Орчлон дэлхий, од, нар, сар түүний хүчээр бүтжээ. Энэ дэлхийн өвс ургамал, цэцэг модод мөн л түүний хүчээр бүтсэн байна. Загас жараахай, жигүүртэн шувууд, араатан амьтад мөн л түүний бүтээл билээ. Энэ бүхний дотроос хамгийн гайхамшигтай бүтээл нь хүн юм. Ертөнцийн Эзэн эрэгтэй хүнийг бүтээснийхээ дараа хир зэрэг ганцаардмал болохыг нь хараад энэ хүнд бүх талаар нь зохицуулан эмэгтэй хүнийг бүтээж өгсөн байна. Анхны эрэгтэй хүнийг Ертөнцийн Эзэн Адаам хэмээн нэрлэсэн бол Адаам эхнэрээ Хаввах хэмээн нэрлэсэн ажээ. Адаам Хаввах хоёрын анхны гэр нь Ертөнцийн Эзэний бэлтгэж өгсөн Эдэн гэгч гайхамшигт цэцэрлэг байлаа. Тэд энд хир зэрэг баяр жаргалтай амьдарсныг бид мэдэхгүй. Ямар ч байсан Ертөнцийн Эзэний үгнээс зөрөлгүй, гэм гэгч юу болохыг мэдэхгүй байхдаа л тэд энд амьдарч байсан байна.

Онцгой хоёр мод

Тэрхүү цэцэрлэгт Ертөнцийн Эзэн хоёр янзын өвөрмөц мод ургуулжээ. Энэ нь Адаам Хаввах хоёрт зориулсан юм биш зөвхөн Ертөнцийн Эзэний өмч байлаа. Цэцэрлэгийн олон модны хамт эдгээрийг бас арчлан хамгаалж байхыг Ертөнцийн Эзэн Адаамд даалгасан боловч тэн-дээс жимс авч идэхийг хоригложээ. Тэр хоёр

модны нэг нь сайн мууг ялган таних чадвар өгөх, нөгөө нь мөнхийн амьдрал өгөх мод байв. Анхны модноос жимс авч идсэн хүн Ертөнцийн Эзэн ба муу ёрын сүнсийг ялган таних чадвартай, хоёрдахь модноос жимс авч идсэн хүн үхэшгүй мөнхийн амьтай болох байв. Ертөнцийн Эзэн Адаам Хаввах хоёрыг өөрийн хүүхдүүд гэж үздэг байсан учир муу юмтай танилцуулахыг хүсээгүй ажээ. Хүн төрөлхтөн бид хүртэл өөрийн хүүхдийг энэ дэлхийн муу муухай юмтай танил-цуулах дургүй байдаг бол Ертөнцийн туйлын ариун эзэн Адаам Хаввах хоёрыг гэмгүй ариун байлгах гэж хир зэрэг их хүссэн нь ойлгомжтой.

Ер бусын элч нар

Энэ дэлхийг бүтээхээсээ олон жилийн өмнө Ертөнцийн Эзэн ер бусын ертөнцийг бас бүтээсэн байжээ. Тэр ертөнц бас өөрийн гэсэн ер бусын оршин суугчтай, тэд бүгд Ертөнцийн Эзэнийг хүндлэн байдаг аж. Тэднийг энэ дэлхийн хүмүүс бид ер бусын элч нар гэж нэрлэдэг. Тэд туйлын нарийн дэг журамтайгаар Ертөнцийн Эзэнд үйлчилдгээс гадна дээд тушаалтай элч нар нь доод тушаалтнаа захирдаг аж. Гэтэл нэгэн дээд тушаалтай элч омог бардам зан гарган Ертөнцийн Эзэний үгийг эсэргүүцэх болсон байна. Түүгээр ч барахгүй талдаа олон элч нарыг татан оруулж, тэдний хамт Ертөнцийн Эзэний хаан ширээг эзлэн авах гэж тэмцэлдэх болов. Үүнийхээ үр дүнд тэд Ертөнцийн Эзэнээс цээрлэл амсаж, ер бусын ертөнцөөс үүрд мөнх тусгаарлагдах шийтгэлийг авчээ. Тэднийг шийтгэх тусгай газрыг Ертөнцийн

Эзэн бэлтгэв. Энэ бол мөнхийн шатаж буй галтай нуур ажээ. Энэ нуурыг мөнхийн зовлон хэмээн нэрлэдэг.

Мэхт арга

Тэрхүү дээд тушаалын хүчит элч Ертөнцийн Эзэнийг үзэн/ ядаж өс хонзон санах боллоо. Тийнхүү Ертөнцийн Эзэний бүтээсэн сайхан юм бүхнийг устгахаар шийдсэн байна. Нэгэн удаа тэрээр могойн дүрстэй болон цэцэрлэгт ирээд Хаввахыг мэхлэн, сайн мууг таниулах модноос жимс авч идэхийг ятгажээ. Хаввах тэндээс жимс авч идснээр барахгүй нөхөртөө бас өгч идүүлэв.

Цээрлэл

Үүний төлөө Ертөнцийн Эзэн тэднийг шийтгэн Эдэн цэцэрлэгээс явахыг тушаалаа. Хэрэв тэд мөнхийн амьдрал өгөгч модноос жимс идчихвэл муу юмыг хийх чадвартайгаа үүрд мөнх амьдрах болно. Ертөнцийн Эзэн хүнийг өөртэйгээ байнга холбоотой байлгах гэж бүтээсэн боловч тэдний хийсэн гэмтэй холбоотой байж чадахгүй байлаа. Ийнхүү Ертөнцийн Эзэний үгийг үл ойшоосноосоо болж анхны гэр бүл хараал хүртэв. Энэ үеэс эхлэн хүний удам угсаа гэм хийх хүсэлтэй төрдөг болжээ. Хүүхэд хэлд орохоосоо ч өмнө төрөлхийн гэм хийх дуртай чанараа харуулж эхэлдэг удаа олонтаа. Ертөнцийн Эзэний тушаалаар тэрхүү сайхан цэцэрлэгээс явах бол-сондоо Адаам Хаввах хоёр маш их харамсч байлаа. Гэвч Ертөнцийн Эзэн тэднийг энэхүү гэмт явдлын боолчлолоос чөлөөлөх нэгэн аврагчийг

хожим дэлхийд илгээх болно гэсэн ам өчгийг өгсөн байна.

Хүслэнт ам өчиг

Энэ тухай хүмүүс бие биедээ үе уламжлан ярьсаар иржээ. Гэмт амьдралын боолчлолоос чөлөөлөх хүний ирэх цагийг хүмүүс олон үеийн туршид хүсэн хүлээж байлаа. Тэгсээр тэсвэр алдан урам хугарах бүр Ертөнцийн Эзэн зарлага илгээж цаашид тэвчин хүлээх нь чухал гэдгийг сануулдаг байсан юм.

Ам өчиг бүрэн биелэгдсэн нь

Ромын хаант улс энэ дэлхийд хүчирхэг болж байсан үед одоогоос бараг хоер мянган жилийн өмнө Ертөнцийн Эзэн амласан үгээ биелүүлэв. Тэр амласан есоор энэ дэлхийд ирсэн хүн бол Есүс байлаа. Есүс гэдэг нь аврагч гэсэн утгатай нэр ажээ. Нөхөрт хараахан гараагүй ариун хэвээрээ байгаа бүсгүйгээс төрөх хүү бол миний илгээсэн тэр аврагч болно хэмээн Ертөншийн Эзэн олон удаа олон хүнээр зөгнүүлэн хэлүүлсэн нь нэгэнт бичигдэн үлджээ. Тэгээд өөрийнхөө элчийг Марь гэгч бүсгүйд илгээв. Ер бусын ар-гаар жирэмсэн болж нэгэн хүү төрүүлэхээ Марь ийнхүү урьдаар мэджээ. Марь эр хүнтэй хавьтаагүй атлаа энэ хүүг төрүүлсэн учраас Есүс бол жирийн нэгэн хүүхэд биш зөвхөн Ертөнцийн Эзэний хүслээр хүн болж төрсөн хүү байлаа.

Есүсийн хийсэн ажил

Есүс Израйль улсад төрөөд гучин гурван жил тэнд амьдарсан байна. Есүс хүмүүст Ертөнцийн

Эзэний хайрыг харуулдаг байлаа. Тэр өвчтэй хүмүүсийг эдгээж, сохор хүмүүсийг хараа оруулж, доголон хүмүүсийг хөлтэй, дүлий хүмүүсийг сонсголтой болгодог басхүү муу ёрын сүнсийг хүнээс зайлуулж, үхсэн хүмүүсийг дахин амилуулж, олон өөр гайхамшгийг бүтээж байсан нь хүмүүсийн санаанд үүрд үлджээ. Хүмүүс бас түүний хайрт татагдан хойноос нь олноор дагадаг байв. Гэвч түүний энэ хүч чадлыг харсан шашин шүтлэгтнүүд атаархан хорссондоо алуулсан юм.

Есүсийг цовдолсон нь

Нэгэн өдөр тэд Есүсийг баривчлан шашны удирдагчийн өмнө авчран байцаалгаад худал мэдүүлгийн үндсэн дээр модон загалмайд цовдлон алах шийдвэр гаргуулав. Ромын хаант улсынхан гэмт хэрэгтнийг ийм аргаар цаазалдаг байлаа.

Есүс дахин амь орсон нь

Тэд одоо л Есүсийг дийллээ хэмээн баярлаж байлаа. Гэвч энэ баяр удаан үргэлжилсэнгүй. Нас барснаасаа хойш гурав хоноод аврагч Есүс-Христ дахин амь оров. Булшнаас гарсан Есүс дөч хоногийн турш энэ дэлхийд байж танил хүмүүстэйгээ өөрийн биеэр олонтаа уулзсан байдаг. Дараа нь энэ дэлхийг орхин Ертөнцийн Эзэний орших газар руу оджээ.

Яагаад тэр үхэв ээ? Түүнд өөрийгөө аврах чадал байгаагүй гэж үү? Түүнийг ер бусын элч нар чөлөөлж чадах байлаа. Яагаад гэвэл тэр

Ертөнцийн аугаа их хүч чадалтай Эзэний хүү байсан юм. Гэвч тэр үхэх ёстой байжээ. Өөртөө шийтгэл оноосон учраас тэр үхсэн билээ. Бидний авах ёстой байсан тэр шийтгэлийг Ертөнцийн Эзэн хүү дээрээ тохжээ. Ийнхүү нэгэнт тасарсан Ертөнцийн Эзэн ба хүн төрөлхтний хоорондох харилцаа дахин сэргэв.

Энэ бол хэн нэгний зохиосон үлгэр биш ээ. Урьд нь огт сонсоогүй хүнд энэ нь хачин сонсог-дож болох боловч түүнд нэгэнт итгэсэн хүний хувьд амар тайван, баяр жаргалын мэдээ болдог юм.

Ертөнцийн Эзэний илгээсэн тэр аврагч бол Есүс гэдэгт та итгэвэл гэмт байдлынхаа хүлээсээс чөлөөлөгдөж түүнээс уучлалт олохоор барахгүй мөнхийн амьдралыг бэлэг бол-гон авах болно. Ийнхүү Есүс таны аврагч болж чадна. Тэр танд хайртай учраас л амиа өгсөн юм. Үүнээс өөр ямар ч шалтгаан түүний үхэлд байгаагүй. Та бас хариуд нь түүнд хайртай болж, түүний төлөө амьдран, түүний тухай бусдад ярих хүсэлтэй болбол Есүсийн сэтгэлд таалагдах болно. Харин та өөрөө үүнийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж Ертөнцийн Эзэний хайрыг голбол хэзээ нэгэн цагт түүний шийтгэлийг хүлээн авах нь гарцаагүй. Та ямар шийтгэлийн тухай төсөөлж байна? Ертөнцийн Эзэн өөрийг нь эсэргүүцэгч бүх хүчийг устгахын тулд мөнхийн гал бэлтгэсэн юм. Энэ үгийг та анхааргтун. «Ертөнцийн Эзэн хүн төрөлхтөнд үнэхээр хайртай учраас ганц хүүгээ илгээсэн юм.

Учир нь, мөнхийн зовлонд орох ёстой хүмүүс хүү Есүст нь итгэвэл мөнхийн амьдралд орж чадна.» («Иоганы бичсэн өгүүллэг» 3-р бүлэг, 16-р зүйл.)

Есүсээс хэрхэн мөнхийн амьдрал хүлээн авах тухай

Есүсийн амьдрал болон үхлийн тухай энэхүү товчхон түүхийг та уншаад түүний замаар явж, Ертөнцийн Эзэний нэгэн их гэр бүлд багтахаар шийдсэн бол толгой гудайн түүний өмнө даруух-наар уучлалт эрэгтүн. Энгийн үгээр түүнээс чин сэтгэлээс уучлалт гуйхдаа та доорхи үгийг хэлж болно. Үүнд: «Ертөнцийн Эзэн минь ээ! Одоо би таны өмнө ирж байна. Би өөрийнхөө гэмт чанарыг хүлээн зөвшөөрье. Тоо томшгүй олон гэмт буруу юм амьдралдаа хийж байсан минь үнэн. Би өөрийгөө өөрчилж чадахгүй нь бас үнэн. Харин та намайг өөрчилж чадна. Иймээс би одоо таны тусламжийг гуйж байна. Миний төлөө амиа зориулсан Есүс танд би их баярлалаа. Миний авах ёстой шийтгэлийг өөрийн биеэр үүрсэнд чинь их баярлалаа. Үүнийг бодож одоо намайг уучлаач. Тэгээд миний бүх гэмт чанарыг зайлуулж өгөөч. Намайг Ертөнцийн Эзэний нэгэн хүүхэд болгож өгөөч. Харин би өөрөө таныг өөрийн аврагч болгоё. Би таныг таны хайраар хайрлах болно. Хэрэгтэй бол би таны төлөө амь насаа ч өгнө. Амьдралыг минь үндсээр нь өөрчилж өөрийн адил ариун сайхан чанартай болгооч.»

© Энд Тайм Хандмайдэнс, 1990

ЕСҮС ГЭЖ ХЭН БЭ?

Орчлон ертөнцийн үүсэл

Олон мянган жилийн өмнө Ертөнцийн Эзэн энэ ертөнцийг бүтээсэн байна. Орчлон дэлхий, од, нар, сар түүний хүчээр бүтжээ. Энэ дэлхийн өвс ургамал, цэцэг модод мөн л түүний хүчээр бүтсэн байна. Загас жараахай, жигүүртэн шувууд, араатан амьтад мөн л түүний бүтээл билээ. Энэ бүхний дотроос хамгийн гайхамшигтай бүтээл нь хүн юм. Ертөнцийн Эзэн эрэгтэй хүнийг бүтээснийхээ дараа хир зэрэг ганцаардмал болохыг нь хараад энэ хүнд бүх талаар нь зохицуулан эмэгтэй хүнийг бүтээж өгсөн байна. Анхны эрэгтэй хүнийг Ертөнцийн Эзэн Адаам хэмээн нэрлэсэн бол Адаам эхнэрээ Хаввах хэмээн нэрлэсэн ажээ. Адаам Хаввах хоёрын анхны гэр нь Ертөнцийн Эзэний бэлтгэж өгсөн Ээдэн гэгч гайхамшигт цэцэрлэг байлаа. Тэд энд хир зэрэг баяр жаргалтай амьдарсныг бид мэдэхгүй. Ямар ч байсан Ертөнцийн Эзэний үгнээс зөрөлгүй, гэм гэгч юу болохыг мэдэхгүй байхдаа л тэд энд амьдарч байсан байна.

Онцгой хоёр мод

Тэрхүү цэцэрлэгт Ертөнцийн Эзэн хоёр янзын өвөрмөц мод ургуулжээ. Энэ нь Адаам Хаввах хоёрт зориулсан юм биш зөвхөн Ертөнцийн Эзэний өмч байлаа. Цэцэрлэгийн олон модны хамт эдгээрийг бас арчлан хамгаалж байхыг Ертөнцийн Эзэн Адаамд даалгасан боловч тэндээс жимс авч идэхийг хоригложээ. Тэр хоёр

модны нэг нь сайн мууг ялган таних чадвар өгөх, нөгөө нь мөнхийн амьдрал өгөх мод байв. Анхны модноос жимс авч идсэн хүн Ертөнцийн Эзэн ба муу ёрын сүнсийг ялган таних чадвартай, хоёрдахь модноос жимс авч идсэн хүн үхэшгүй мөнхийн амьтай болох байв. Ертөнцийн Эзэн Адаам Хаввах хоёрыг өөрийн хүүхдүүд гэж үздэг байсан учир муу юмтай танилцуулахыг хүсээгүй ажээ. Хүн төрөлхтөн бид хүртэл өөрийн хүүхдийг энэ дэлхийн муу муухай юмтай танилцуулах дургүй байдаг бол Ертөнцийн туйлын ариун эзэн Адаам Хаввах хоёрыг гэмгүй ариун байлгах гэж хир зэрэг их хүссэн нь ойлгомжтой.

Ер бусын элч нар

Энэ дэлхийг бүтээхээсээ олон жилийн өмнө Ертөнцийн Эзэн ер бусын ертөнцийг бас бүтээсэн байжээ. Тэр ертөнц бас өөрийн гэсэн ер бусын оршин суугчтай, тэд бүгд Ертөнцийн Эзэнийг хүндлэн байдаг аж. Тэднийг энэ дэлхийн хүмүүс бид ер бусын элч нар гэж нэрлэдэг. Тэд туйлын нарийн дэг журамтайгаар Ертөнцийн Эзэнд үйлчилдгээс гадна дээд тушаалтай элч нар нь доод тушаалтнаа захирдаг аж. Гэтэл нэгэн дээд тушаалтай элч омог бардам зан гарган Ертөнцийн Эзэний үгийг эсэргүүцэх болсон байна. Түүгээр ч барахгүй талдаа олон элч нарыг татан оруулж, тэдний хамт Ертөнцийн Эзэний хаан ширээг эзлэн авах гэж тэмцэлдэх болов. Үүнийхээ үр дүнд тэд Ертөнцийн Эзэнээс цээрлэл амсаж, ер бусын ертөнцөөс үүрд мөнх тусгаарлагдах шийтгэлийг авчээ. Тэднийг шийтгэх тусгай газрыг Ертөнцийн

Эзэн бэлтгэв. Энэ бол мөнхийн шатаж буй галтай нуур ажээ. Энэ нуурыг мөнхийн зовлон хэмээн нэрлэдэг.

Мэхт арга

Тэрхүү дээд тушаалын хүчит элч Ертөнцийн Эзэнийг үзэн/ ядаж өс хонзон санах боллоо. Тийнхүү Ертөнцийн Эзэний бүтээсэн сайхан юм бүхнийг устгахаар шийдсэн байна. Нэгэн удаа тэрээр могойн дүрстэй болон цэцэрлэгт ирээд Хаввахыг мэхлэн, сайн муут таниулах модноос жимс авч идэхийг ятгажээ. Хаввах тэндээс жимс авч идснээр барахгүй нөхөртөө бас өгч идүүлэв.

Цээрлэл

Үүний төлөө Ертөнцийн Эзэн тэднийг шийтгэн Ээдэн цэцэрлэгээс явахыг тушаалаа. Хэрэв тэд мөнхийн амьдрал өгөгч модноос жимс идчихвэл муу юмыг хийх чадвартайгаа үүрд мөнх амьдрах болно. Ертөнцийн Эзэн хүнийг өөртэйгээ байнга холбоотой байлгах гэж бүтээсэн боловч тэдний хийсэн гэмтэй холбоотой байж чадахгүй байлаа. Ийнхүү Ертөнцийн Эзэний үгийг үл ойшоосноосоо болж анхны гэр бүл хараал хүртэв. Энэ үеэс эхлэн хүний удам угсаа гэм хийх хүсэлтэй төрдөг болжээ. Хүүхэд хэлд орохоосоо ч өмнө төрөлхийн гэм хийх дуртай чанараа харуулж эхэлдэг удаа олонтаа. Ертөнцийн Эзэний тушаалаар тэрхүү сайхан цэцэрлэгээс явах болсондоо Адаам Хаввах хоёр маш их харамсч байлаа. Гэвч Ертөнцийн Эзэн тэднийг энэхүү гэмт явдлын боолчлолоос чөлөөлөх нэгэн аврагчийг

хожим дэлхийд илгээх болно гэсэн ам өчгийг өгсөн байна.

Хүслэнт ам өчиг

Энэ тухай хүмүүс бие биедээ үе уламжлан ярьсаар иржээ. Гэмт амьдралын боолчлолоос чөлөөлөх хүний ирэх цагийг хүмүүс олон үеийн туршид хүсэн хүлээж байлаа. Тэгсээр тэсвэр алдан урам хугарах бүр Ертөнцийн Эзэн зарлага илгээж цаашид тэвчин хүлээх нь чухал гэдгийг сануулдаг байсан юм.

Ам өчиг бүрэн биелэгдсэн нь

Ромын хаант улс энэ дэлхийд хүчирхэг болж байсан үед одоогоос бараг хоер мянган жилийн өмнө Ертөнцийн Эзэн амласан үгээ биелүүлэв. Тэр амласан есоор энэ дэлхийд ирсэн хүн бол Есүс байлаа. Есүс гэдэг нь аврагч гэсэн утгатай нэр ажээ. Нөхөрт хараахан гараагүй ариун хэвээрээ байгаа бүсгүйгээс төрөх хүү бол миний илгээсэн тэр аврагч болно хэмээн Ертөншийн Эзэн олон удаа олон хүнээр зөгнүүлэн хэлүүлсэн нь нэгэнт бичигдэн үлджээ. Тэгээд өөрийнхөө элчийг Марь гэгч бүсгүйд илгээв. Ер бусын аргаар жирэмсэн болж нэгэн хүү төрүүлэхээ Марь ийнхүү урьдаар мэджээ. Марь эр хүнтэй хавьтаагүй атлаа энэ хүүг төрүүлсэн учраас Есүс бол жирийн нэгэн хүүхэд биш зөвхөн Ертөнцийн Эзэний хүслээр хүн болж төрсөн хүү байлаа.

Есүсийн хийсэн ажил

Есүс Израйль улсад төрөөд гучин гурван жил тэнд амьдарсан байна. Есүс хүмүүст Ертөнцийн

Эзэний хайрыг харуулдаг байлаа. Тэр өвчтэй хүмүүсийг эдгээж, сохор хүмүүсийг хараа оруулж, доголон хүмүүсийг хөлтэй, дүлий хүмүүсийг сонсголтой болгодог басхүү муу ёрын сүнсийг хүнээс зайлуулж, үхсэн хүмүүсийг дахин амилуулж, олон өөр гайхамшгийг бүтээж байсан нь хүмүүсийн санаанд үүрд үлджээ. Хүмүүс бас түүний хайрт татагдан хойноос нь олноор дагадаг байв. Гэвч түүний энэ хүч чадлыг харсан шашин шүтлэгтнүүд атаархан хорссондоо алуулсан юм.

Есүсийг цовдолсон нь

Нэгэн өдөр тэд Есүсийг баривчлан шашны удирдагчийн өмнө авчран байцаалгаад худал мэдүүлгийн үндсэн дээр модон загалмайд цовдлон алах шийдвэр гаргуулав. Ромын хаант улсынхан гэмт хэрэгтнийг ийм аргаар цаазалдаг байлаа.

Есүс дахин амь орсон нь

Тэд одоо л Есүсийг дийллээ хэмээн баярлаж байлаа. Гэвч энэ баяр удаан үргэлжилсэнгүй. Нас барснаасаа хойш гурав хоноод аврагч Есүс-Христ дахин амь оров. Булшнаас гарсан Есүс дөч хоногийн турш энэ дэлхийд байж танил хүмүүстэйгээ өөрийн биеэр олонтаа уулзсан байдаг. Дараа нь энэ дэлхийг орхин Ертөнцийн Эзэний орших газар руу оджээ.

Яагаад тэр үхэв ээ? Түүнд өөрийгөө аврах чадал байгаагүй гэж үү? Түүнийг ер бусын элч нар чөлөөлж чадах байлаа. Яагаад гэвэл тэр

Ертөнцийн аугаа их хүч чадалтай Эзэний хүү байсан юм. Гэвч тэр үхэх ёстой байжээ. Өөртөө шийтгэл оноосон учраас тэр үхсэн билээ. Бидний авах ёстой байсан тэр шийтгэлийг Ертөнцийн Эзэн хүү дээрээ тохжээ. Ийнхүү нэгэнт тасарсан Ертөнцийн Эзэн ба хүн төрөлхтний хоорондох харилцаа дахин сэргэв.

Энэ бол хэн нэгний зохиосон үлгэр биш ээ. Урьд нь огт сонсоогүй хүнд энэ нь хачин сонсогдож болох боловч түүнд нэгэнт итгэсэн хүний хувьд амар тайван, баяр жаргалын мэдээ болдог юм.

Ертөнцийн Эзэний илгээсэн тэр аврагч бол Есүс гэдэгт та итгэвэл гэмт байдлынхаа хүлээсээс чөлөөлөгдөж түүнээс уучлалт олохоор барахгүй мөнхийн амьдралыг бэлэг болгон авах болно. Ийнхүү Есүс таны аврагч болж чадна. Тэр танд хайртай учраас л амиа өгсөн юм. Үүнээс өөр ямар ч шалтгаан түүний үхэлд байгаагүй. Та бас хариуд нь түүнд хайртай болж, түүний төлөө амьдран, түүний тухай бусдад ярих хүсэлтэй болбол Есүсийн сэтгэлд таалагдах болно. Харин та өөрөө үүнийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж Ертөнцийн Эзэний хайрыг голбол хэзээ нэгэн цагт түүний шийтгэлийг хүлээн авах нь гарцаагүй. Та ямар шийтгэлийн тухай төсөөлж байна? Ертөнцийн Эзэн өөрийг нь эсэргүүцэгч бүх хүчийг устгахын тулд мөнхийн гал бэлтгэсэн юм. Энэ үгийг та анхааргтун. «Ертөнцийн Эзэн хүн төрөлхтөнд үнэхээр хайртай учраас ганц хүүгээ илгээсэн юм.

Учир нь, мөнхийн зовлонд орох ёстой хүмүүс хүү Есүст нь итгэвэл мөнхийн амьдралд орж чадна.» («Йоганы бичсэн өгүүллэг» 3-р бүлэг, 16-р зүйл.)

Есүсээс хэрхэн мөнхийн амьдрал хүлээн авах тухай

Есүсийн амьдрал болон үхлийн тухай энэхүү товчхон түүхийг та уншаад түүний замаар явж, Ертөнцийн Эзэний нэгэн их гэр бүлд багтахаар шийдсэн бол толгой гудайн түүний өмнө даруухнаар уучлалт эрэгтүн. Энгийн үгээр түүнээс чин сэтгэлээс уучлалт гуйхдаа та доорхи үгийг хэлж болно. Үүнд: «Ертөнцийн Эзэн минь ээ! Одоо би таны өмнө ирж байна. Би өөрийнхөө гэмт чанарыг хүлээн зөвшөөрье. Тоо томшгүй олон гэмт буруу юм амьдралдаа хийж байсан минь үнэн. Би өөрийгөө өөрчилж чадахгүй нь бас үнэн. Харин та намайг өөрчилж чадна. Иймээс би одоо таны тусламжийг гуйж байна. Миний төлөө амиа зориулсан Есүс танд би их баярлалаа. Миний авах ёстой шийтгэлийг өөрийн биеэр үүрсэнд чинь их баярлалаа. Үүнийг бодож одоо намайг уучлаач. Тэгээд миний бүх гэмт чанарыг зайлуулж өгөөч. Намайг Ертөнцийн Эзэний нэгэн хүүхэд болгож өгөөч. Харин би өөрөө таныг өөрийн аврагч болгоё. Би таныг таны хайраар хайрлах болно. Хэрэгтэй бол би таны төлөө амь насаа ч өгнө. Амьдралыг минь үндсээр нь өөрчилж өөрийн адил ариун сайхан чанартай болгооч.»

© Энд Тайм Хандмайдэнс, 1990